



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/18

Номгон

Төрийн архивын баримтыг 2025-2029 онуудад
иж бүрэн нягтлан шалгах бодлого, чиглэлийг
хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/683 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн архивын баримтыг 2025-2029 онуудад иж бүрэн нягтлан шалгах бодлого, чиглэл”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Төрийн архивын баримтыг 2025-2029 онуудад иж бүрэн нягтлан шалгах бодлого, чиглэл”-ийг 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төрийн архивын баримтыг иж бүрэн нягтлан шалгах бодлого, чиглэлийг үйл ажиллагаандаа баримталж, 2026 оны төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг зохион байгуулж, арга зүйгээр ханган хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Төрийн архивын хэлтэс (В.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 4/18 дугаар захирамжийн
хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨРИЙН АРХИВЫН БАРИМТЫГ 2025-2029 ОНУУДАД
ИЖ БҮРЭН НЯГТЛАН ШАЛГАХ БОДЛОГО ЧИГЛЭЛИЙГ 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго		Сан хөмрөгт байгаа баримтыг системчлэх, ангилах, мэдээллийн давхардлыг арилгах, цахим санд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, эмх цэгц, лавлагаа мэдээллийг түргэн шуурхай хайлт хийж олгох нөхцөлийг бүрдүүлэхэд бодлого чиглэлийн зорилго оршино.				
Үр нөлөө		Төрийн болон байгууллагын архивын мэдээлэл, эрэл хайлтын үйл ажиллагаа автоматжиж шинэ шатанд гарч, архивыг судлах, сонирхох, олон нийтийн хэрэгцээ өсөн нэмэгдэж мэдээллийг цахим хэлбэрээр ашиглах боломж бий болж архив нээлттэй, хүртээмжтэй байх хуулийн зарчим бүрэн хэрэгжиж баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлж хадгалалт хамгаалалт, эмх цэгц сайжирна.				
д/д	Үйл ажиллагаа		Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хянан хэрэгжүүлэх байгууллага	Төсөв
1	2	3	4	5	6	7
Зорилт 1: Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтыг нягтлан шалгах						
1	1.1	Төрийн архивын сангаас баримтыг түүвэр хэлбэрээр иж бүрэн нягтлан шалгах, хяналт тавих холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах	5 хүртэлх хөмрөг	Төрийн архивын хэлтэс	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв
Зорилт 2: Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтыг мэдээллийн системд шилжүүлэх үед нягтлан шалгах						
2	2.1	Төрийн архивын сангаас баримтыг цахим санд шилжүүлэх явцад иж бүрэн нягтлан шалгах, хяналт тавих холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах	5 хүртэлх хөмрөг	Төрийн архивын хэлтэс	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн болон улсын төсөв

1	2	3	4	5	6	7
Зорилт 3: Төрийн архивын сан хөмрөгт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар баримт хүлээн авсан баримтыг нягтлан шалгах						
3	3.1	Төрийн архивын санд хүлээн авч байгаа баримтыг ангилах бүрдүүлэх, эмхлэн цэгцлэх, цахим санд шилжүүлэх явцад иж бүрэн нягтлан шалгах, хяналт тавих холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах	160 хүртэлх байгууллагын 2023 оны болон бусад баримт	Төрийн архивын хэлтэс	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн болон улсын төсөв
Зорилт 4: Төрийн архивын сан хөмрөгийн тоо бүртгэлийн баримтыг иж бүрэн нягтлан шалгах						
4	4.1	Төрийн архивын сан хөмрөгийн тоо бүртгэлийн баримтыг иж бүрэн нягтлан шалгах холбогдох арга хэмжээг зохион байгуулах	1.Төрийн архивын 50 хүртэлх хөмрөг 2.Мөн 160 хүртэлх байгууллагын 2023 оны тоо бүртгэл,	Төрийн архивын хэлтэс	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн болон улсын төсөв

-----oOo-----



دسترس مستقیم به داده‌های حساس

[illegible]

مفتی محمد سعید علی صاحبزادہ، پروفیسر، جامعہ اسلامیہ، لاہور۔ ۱۹۵۵ء-۱۹۸۵ء

[illegible]

642501729